



**“БЭРХ УУЛ” ХК – ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020 оны 3 сарын 09 өдөр.

Дугаар 11/2020

Улаанбаатар

Г

7

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай**

“Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, дийлэнх олонхийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бэрх Уул” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 24-ний Баасан гарагт 09:00 цагт Хэнтий аймаг, Батноров сум, Бэрх тосгон дахь “Бэрх Уул” ХК-ын оффисын хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
 - a. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
 - b. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
 - c. 2020 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
 - d. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - e. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2020 оны зардлын төсвийг батлах
 - f. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
 - g. Бэрхийн уурхайн “Уулын цех”-ийн хэсгийг түшиглэн Далд уурхайн музей байгуулахтай холбоотой гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
 - h. Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай ТУЗ-ын бэлтгэсэн төслийг хэлэлцэн батлах
 - i. “Бэрх Уул” ХК-ийн эсрэг “MNUB кредит” ХХК-ийн шүүхийн нэхэмжлэлтэй хэргийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
 - j. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
 - k. Хөрөнгө шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

1. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлах
- m. Зээл, өр төлбөрийн талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр буюу баасан гарагт, өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээллэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 17 хоногийн дараа буюу 03 сарын 30-ны өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2020 оны 03 сарын 17-ны өдрөөс хойш 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд Хан-уул дүүрэг, 15 хороо, Махатма гандигийн гудамж, Модерн Таун хотхон, 201 тоотод ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах өдрийг хүртэл байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Даваажав, хурал зохион байгуулах комиссын даргаар А.Даваажав, гишүүдээр Н.Содончимэг, Б.Баярцэнгэл, Тооллогын комиссын даргаар Э.Уянга, гишүүдээр Л.Тэмүүжин, Ё.Амарбат нарыг тус тус томилсугай

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Р.БАДРАХ